

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

ДОКТОР, ПРОФЕССОР Т.БААСАНСҮРЭНГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН
СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

М.Наранчимэг*

* “Улаанбаатар Эрдэм” их сургуулийн Сэтгүүл зүй, олон улс судлалын тэнхимийн багш, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: сэтгүүл зүйн судалгаа, хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн ур чадвар, нийтлэлийн дурсгалт бичиг, ууган тогтмол хэвлэл, асуудал дэвшүүлсэн нийтлэл

Тугалхүүгийн Баасансүрэн нь мэргэжлийн сэтгүүлч, сэтгүүл зүйн судлаач, шүүмжлэгч, Монголын үргэлжилсэн үгийн нэрд гарсан зохиолч юм. Тэрээр үе үеийн сэтгүүлчдийн нийтлэлд дүн шинжлэл хийж нийтдээ зуугаад шүүмж бичсэн байдаг. Түүний “Ганчимэг гайхшруулж, бас бахархал төрүүлж байна”, “Сэтгүүлчийн ширээний ном бичсэн хүний тухай өгүүлэх нь”, “Хос мэргэжил эзэмшихийн хосгүй давуу тал”, “Баримтаас дүр бүтэх ёсон” зэрэг судалгаа сайтай, үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгсөн цөөнгүй шүүмж нь Монголын сэтгүүл зүйн шүүмж, судлалд томоохон байр эзэлдэг юм. Эдгээр шүүмжүүд нь сэтгүүл зүйн судлаач, уншигчдаас өндөр үнэлэлт авч их, дээд сургуулиудын сэтгүүл зүйн ангийн оюутнуудад судалгааны хэрэглэгдэхүүн болон ашиглагдаж байна.

Судлаач Т.Баасансүрэнгийн бусдаас ялгарах нэг онцлог нь сүүлийн гучаад жилд тасралтгүй их, дээд сургуульд багшилж өөрийн мэдлэг туршлагыг залуу хойч үеийхэндээ өвлүүлэн шавь бэлтгэж ирсэн явдал юм. Сэтгүүл зүйн онол, практикийн асуудлаар хорь гаруй ном бичсний дотор “ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” /I ба II хэсэг, 2009/, “1921 оны ардын хувьсгал ба монголын хэвлэлийн цаашдын хөгжил” /2009/, “1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв” /2009/, “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь” /2010/, “Монголд чөлөөт хэвлэл “устгах” аюул нүүрлэж байна” /2016/ хэмээх 6 ботийг багтаасан “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” цуврал бүтээлүүд нь монголын сэтгүүл зүйн шүүмж, судлал болон онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Мөн 2014 онд туурвиж уншигчид даа өргөн барьсан “Монголын нууц товчоо” нийтлэлийн дурсгалт бичиг мөн” ном нь шинжлэх ухаанд шинэ үг

хэлсэн онцгой бүтээл болсныг манай утга зохиол, сэтгүүл зүй судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэхүү судалгааны тойм өгүүлэлд эрдэмтэн багшийнхаа дээрх олон арван судалгааны бүтээлээс зөвхөн “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” цувралаар бүтээгдсэн зургаан боть судалгааны бүтээлд дүн шинжилгээ хийж, үнэдлэлт дүгнэлт өгөхийг зорив.

“**Х**Х зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” тэргүүн дэвтрийн оршилд нь МУСГЗ, түүхийн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн профессор М.Зулькафиль “Манай орны сэтгүүл зүйн 100 орчим жилийн түүхэн туршлага, нийтлэлийн төрөл зүйл, уран чадварын уламжлал, шинэчлэлийг түүхчлэн үзэх, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, агуулгад дүн шинжилгээ хийх, нэгжээс ерөнхий, ерөнхийгөөс нэгж рүү шилжих, харьцуулан судлах зэрэг сэтгүүл зүйн судлалд түгээмэл хэрэглэдэг нийтлэг аргуудыг хэрэглэж, сэтгүүл зүйн хөгжил, төлөвшлийн асуудлыг олон талаас цогц байдлаар судлахыг сэтгүүл зүйн өнөөгийн нөхцөл шаардаж буйг судлаач соргоогоор олж харж, оновчтой бүтэц, орон зай, цаг хугацааны дарааллыг тодорхой хэмжээгээр хадгалах замаар судалсан бүтээл”¹ болсныг тэмдэглэжээ. МУСГЗ, доктор, профессор Сономын Лочин уг бүтээлийг агуулгын талаас нь үнэлж цэгнээд “Т.Баасансүрэнгийн эдгээр ботид Монголын сэтгүүл зүйн түүхийн олон асуудлыг цоо шинэ өнцгөөс харж туурвиснаараа, ахмад залуу сэтгүүлчдийн шилдэг бүтээлийг задлан шинжилснээрээ, чөлөөт хэвлэл төлөвшин тогтох бартаат замын ололт амжилт, гашуун үнэнийг дэлгэж, түүхэн зарчмыг дагаснаараа чөлөөт хэвлэ-

лийн өчигдөр өнөөдрийн байдлыг нэгтгэн дүгнэж цаашдын төлөвийг тодорхойлсноороо үнэ цэнэтэй бүтээл болжээ”² гэж онцолжээ.

“ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” хэмээх тэргүүн дэвтэрт Монголын сэтгүүл зүйн үндэс суурийг тавьсан ууган тогтмол хэвлэл болох “Шинэ толь хэмээх бичиг” сонин, тус сонины үзэл санааг үргэлжлүүлсэн “Нийслэл хүрээний сонин бичиг”, 1921 оны ардын хувьсгалын дараахан гарч, шинэ хэлбэрийн сонин, сэтгүүл, мэдээллийн хэрэгсэл хөгжих суурийг тавьсан хэвлэлүүдийг төлөөлүүлэн “Монголын үнэн”, “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень Монгольского телеграфно-го агентства” (орос хэлээр) 1922-1923 оны сонинуудын нийтлэлд задлан шинжлэл хийж, “Бюллетень МОНТА” сонины хадгалагдаж үлдсэн бүх дугаарын нийтлэлийг монгол бичиг, орос хэлнээс орчин цагийн кирилл бичигт хөрвүүлсэн нь оюутан, судлаач нарт гарын авлага, судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломжийг бүрдүүлжээ. Мөн судлаач дээрх хэвлэлүүдийн нийтлэлд дэлгэрэнгүй задлан шинжлэл хийсэн нэн шинэлэг юм. Тухайлбал, “Шинэ толь хэмээх бичиг” сонины нийтлэлүүдийг танин мэдүүлж, соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн нийтлэлүүд, улс төр, эдийн засгийн тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд чиглэгдсэн нийтлэлүүдгэх зэргээр сэдэвчлэн бүлэглээд тодорхой жишээ татан, тайлбар дүгнэлт хийжээ. Тус сонин шинжлэх ухаанч чиг хандлагыг баримталж, Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсныг тэмдэглээд улс орон бэхжихэд хамгийн түрүүнд анхаарах зүйл эдийн засгаас хараат бус байх явдал гэдгийг ухааран, төр засагт

сануулж, сонины бодлогынхоо тэргүүн эгнээнд тавьж байсан, дэвшилт бүхнийг түгээн дэлгэрүүлэхэд, нийгмийн хөгжилд саад бологч хуучирсан ёс заншил, дутагдлыг шүүмжлэн, хурц дайчин шүүмжлэлт нийтлэлээрээ онцгойрч, дэлхий дахины байдлын талаар үнэн зөв мэдээллийг түгээж байсныг судлаач гярхай ажиглажээ. Монголчууд бусад орноос юуг сурч мэдвэл ашиг тустайг онцлох зорилгоо болгож байсныг, сонинд ажиллаж байсан сурвалжлагчид нь сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлүүдийг чадмаг ашиглаж, хэл найруулгын хувьд утга зохиолын бичгийн монгол хэлээр ончтой үг хэллэг хэрэглэж, шинжлэх ухааны мэдлэгийг уншигчдад ойлгомжтой үгээр хүргэж чадаж байсныг жишээ баримттайгаар батлан өгүүлсэн нь мэдээллийн хувьд сонирхолтой төдийгүй сэтгүүл зүйн судалгааны хувьд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан судлах аргуудыг хослуулан хэрэглэснээрээ маш өвөрмөц онцлогтой юм. Энэ утгаараа зөвхөн сэтгүүл зүй судлаачид төдийгүй, мэргэжлийн ангийн оюутнууд, өмнөх түүхээ сонирхогч хэн бүхэнд тустай санаа авахуйц бүтээл болжээ.

Зохиогч “тус сонины танин мэдүүлж, соён гэгээрүүлэхэд зориулсан мэдээлэл нь улс орны аж ахуй, эдийн засгийн хамгийн эмзэг асуудлыг заавал хөндөж, түүнд анхаарлаа хандуулж байснаараа үнэ цэнэтэй сонин юм гээд “Шинэ толь хэмээх бичиг” сонинихон улс орны тусгаар тогтнолыг хүчирхэг эдийн засагтай ямагт холбон ойлгож, нийтлэлдээ тусгаж байсан нь онцгой анхаарал татаж байна. Тус сонинд шинжлэх ухааны ололт амжилтыг сурталчлан таниулахын зэрэгцээ Монголоо хөгжүүлэх, хөл дээр нь босгох туйлын зорилго

байсан байна”³ хэмээн дүгнэсэнтэй санал нэг байна.

Тус бүтээлийн хоёрдугаар бүлэгт “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины нийтлэлийн онцлог, үүрэг, зорилго, ач холбогдол, сэтгүүл зүйн үүргийг тодруулж, Монголын анхны тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” сонины бодлогыг үргэлжлүүлэгч, залгамжлагч сонин гэдгийг тодорхой жишээ баримтаар нотлон харуулжээ. Үүний нэг тод жишээ бол “Шинэ толь хэмээх бичиг” сониныг үүсгэн байгуулагч Жамсраны Цэвээн тус сонины эрхлэгч байсан, “Түмэн зүйлийг бадруулж, элдэв ухааныг нэвтрүүлнэ” гэсэн сонины уриаг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн явдал юм. “Нийслэл хүрээний сонин бичиг” 1915 оны 2 дугаарт “Сонсгол” гарчгийн дор “Эдүгээ манай Нийслэл хүрээний сонин бичиг”-ийн хороо урьд “Шинэ толь”-ийн хороо гэгдэж байсан, тэрчлэн “Нийслэл хүрээний сонин бичиг” нь өмнөх хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” сониныг эрхлэн гаргалцаж байсан уран бүтээлч, сэтгүүлчдийн бүрэлдэхүүнээр давхар нотлогдож байна. Өмнө нь “Шинэ толь хэмээх бичиг” сонинд ажиллаж байсан Ж.Цэвээн, Д.Бодоо, Д.Бадрахбаатар, Б.Дорж нарын зэрэг шилдэг нийтлэлчид “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд үргэлжлэн ажиллаж уг сонины гол нийтлэлүүдийг бичиж байжээ. Нийтлэлийн бодлогоороо “Шинэ толь хэмээх бичиг” ба “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинууд нь адил төстэй байсныг баримтаар харьцуулан дүгнэжээ. Эдгээр нотолгоо, баримтууд нь судлаач Т.Баасансүрэнд “Шинэ толь хэмээх бичиг” сониныг залгамжлагч нь “Нийслэл хүрээний сонин бичиг” мөн гэсэн дүгнэлт хийх үндэс болжээ. Мөн тус сонины нийтлэлийг түмэн зүйлийн сониныг түгээн мэдээлэгч, тусгаар

тогтнол, хөгжил дэвшлийн төлөө тууштай тэмцэгч, шинэ цагийн боловсрол, шинжлэх ухаанд уриалан дуудагч, харанхуй бүдүүлгийг арилгахаар харанга дэлдсэн сонин гэж үзээд нийтлэлүүдийг нь багцлан ангилж ажиглалт, дүгнэлт хийсэн байна. Тус сонинд мэдээ, мэдээллийн төрөл давамгайл байгааг онцлон тэмдэглээд, Монгол Улсын хөгжлийн хөтөч, ардчилсан дэвшилт хэвлэлийн илэрхийлэл “Шинэ толь хэмээх бичиг” сонин үзэл санааг үргэлжлүүлэгч, шинэ цагийн боловсрол, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухааны ололт амжилтыг түгээгч, тухайн цаг үеийн тэргүүний дэвшилт арга ажиллагаа бүгдийг Монголын хөрсөнд суулган цэцэглүүлэн, бадруулахын төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэгч сонин гэсэн сонирхолтой дүгнэлт хийжээ.

Монголын хэвлэлийн түүхэн дэх нийтлэлийн соён гэгээрүүлэх чиглэлийн үүргийг өндөр түвшинд биелүүллсэн, орчин үеийн сэтгүүл зүйд тавигддаг мэдээлэгч үүргээс эхлээд сэтгүүл зүйн үндсэн зарчмыг ч ямар нэг хэмжээгээр биелүүлж байсан гэж дүгнэсэнтэй санал нэг байна. Судлаач энэ бүтээлдээ маш их цаг зарж, оюун бодол, сэтгэл зүрхээ зориулсан нь уг судалгааны бүтээлийг уншиж байхад тод мэдрэгддэг. Дээрх хоёр сонин нийтлэл бүрийг шимтэн судалж, харьцуулан жишиж байж бүтээсэн энэхүү ном нь Монголын сэтгүүл зүйн түүхийг судлаачдад том олз болно гэдэг итгэлтэй байна.

“Нийслэл хүрээний сонин бичиг”-ийн ихэнх нийтлэл нь феодалын нийгмийн хоцрогдол, улс орны хөгжил, боловсрол, соёл, эрүүл мэнд, шинжлэх ухааны шинэ ололтод саад хийгч бүхнийг шүүмжилсэн өнгө аястай нийтлэл байсан бөгөөд тэднийг “Шүүмж-

лэл” гэсэн байнгын буланд нийтлэхийн зэрэгцээ нэг асуудлыг ганц бичээд орхих бус ахин дахин нийтэлж цуврал нийтлэлээр дутагдлыг арилгах гэж оролддог онцлогтой байжээ. Судлаач ажиглалтаа тус сонинд цувралаар нийтлэгдсэн нэг жишээн дээр баталгаажуулан дэлгэрүүлж өгүүлсэн бол илүү өгөөжтэй болох байсан гэж бодож байна. Тухайн буланд нийтлэгдсэн олон жишээг авч номондоо оруулан сонирхолтой тайлбар зүүлт хийсэн боловч бүтээлд дурьдсан цуврал шүүмжлэлт нийтлэлийн жишээг иш татаж оруулаагүй байна.

“Х зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” тэргүүн дэвтрийн II хэсгийг бүхэлд нь МОНТА буюу МОНЦАМЭ агентлагийн өчигдөр, өнөөдөр, маргаашийн үйл ажиллагааны талаар бичжээ. МОНТА-гаас 1922-1923 онд монгол хэлээр гаргаж байсан “Хураангуй сэтгүүл”, орос хэл дээр хэвлүүлж байсан “Бюллетень МОНТА” сонинуудын тухайн цаг үед Улсын нийтийн төв номын санд хадгалагдаж байсан бүх дугаарын нийтлэлийг орчин цагийн кирилл рүү буулгаж бүтээлдээ хавсаргасан нь онцгой ач холбогдолтой юм. Учир нь дээрх сонинуудын эхийг олж үзэхээр миний бие Төв номын санд хэд хэдэн удаа очоод гүйцэд олж харж чадаагүй, зарим дугаар нь алга болсон байсан.

Судлаач Т.Баасансүрэн аливаа судалгаа шинжилгээ, бүтээлдээ чин сэтгэлээсээ ханддаг бөгөөд хийсэн бүтээл туурвилаас нь түүний өөрийнх нь сэтгэлийг уншиж болохоор байна. “МОНЦАМЭ” хэмээх Монгол орныг дэлхийн улс оронд таниулдаг энэ айлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч асан Нацагийн Багабандийн тодорхойлон хэлсэнчлэн “Үе үеийн шилдэг сэтгүүлчид, тоймч, орчуулагч-

дын “Ариун номын ордон”-ы өчигдрийн түүх бүрхэг, өнөөдөр нь ойлгомжтой атлаа ирээдүй нь бас бүдэгдүүхэн байгааг соргоогоор мэдэрч, энэ айлын үүцэлсэн түүхийг мэдэх ахмад сэтгүүлчид, өмнө нь тус агентлагийн даргаар ажиллаж байх үедээ хүмүүстэй уулзаж, “Миний нэр, Миний гэр МОНЦАМЭ” хэмээх найман бүлэг 220 хуудастай бүтээл туурвисан байна. Энэ бүтээлд МОНЦАМЭ-гийн 80 жилийн түүхийг багцлан оруулж энэ айлыг түүхтэй болгосон том гавъяаг байгуулжээ”.

Судлаач “Бюллетень МОНТА” сонины 1923 оны нэгдүгээр сарын №50,51-д “Монголын цахилгаан мэдээний агентлаг-МОНТА-гийн үйл ажил-лагааны товч тайлан” гэсэн таван өгүүлбэртэй мэдээг онцолсон байна. Онцолсны учир энэ багц мэдээ 1922 оны МОНТА-гийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгч, тухайн үед Монгол оронд Бюллетений 47 дугаарт нийт 22500 мэдээхэвлэгдсэн, энэ мэдээнд Монгол Улсын улс төр, эдийн засгийн, аж ахуйн амьдралын талаар монгол, орос хэлээр гаргаж, Монголыг гадаадад байнга сурталчилж байснаараа чухал ач холбогдолтой юм.

“1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил” хэмээх дэд дэвтэр нь бүхэлдээ 1920-1921 оны ардын хувьсгалын жилүүдэд Монгол орныхоо тусгаар тогтнол, өвөг дээдсээс уламжлан үеэс үед дамжуулан ирсэн газар шорооныхоо төлөө амь бие, оюун ухаан, сэтгэлээ зориулж ирсэн энгийн ард зонихоо амгалан амьдрал, өөрийн газар нутаг дээр эзэн болж, эрх жаргалант амьдралаар ард олноо амьдруулахын төлөө өөрсдийн эрдэм мэдлэгийг ашиглан олон аргаар тэмцлийн замыг сонгож тууштай тэмцсэн сонины талаар дэлгэрэнгүй өгүүл-

жээ. 1920 оны 11-р сарын 10-нд “Монголын үнэн” сонины анхны дугаар хэвлэгдсэн бол 1921 оны 4-р сарын 19-нд сүүлчийн дугаар хэвлэгдсэн байна. Нийт 6 дугаар хэвлэгдсэн бөгөөд тус сонин “Ард олны чөлөө эрх, дэлхий дахинаа наран мэт бадран, Монгол улсын язгуур үндэс эрдэм соёл нь дэлгэрэн мандах болтугай! хэмээн өөрсдийн үйл хэрэг, үзэл бодлоо илэрхийлсэн уриатай байжээ. “Монголын үнэн” сонинг эрхлэн гаргагч нь Монгол ардын нам, Коминтерний алс дорнодын хорооны Монгол, Төвдийн хэлтэс гэж бичээстэй байгаа боловч түүнийг Оросын хувьсгалчид дэмжлэг үзүүлж, Монголын хувьсгалчид өөрсдөө эрхлэн гаргаж байсан гэсэн дүгнэлтэд хүрчээ. Ардын хувьсгалыг зэр зэвсгийн хүчээр хийж, Хятадын болоод Оросын цагаантны харгисуудыг Монголоос хөөн зайлуулах тэмцэлд нийт ард түмнийг, журамт цэргийг ил тод уриалан дуудсан цорын ганц хэвлэл бол “Монголын үнэн” сонин гэж судлаачийн дүгнэсэнтэй санал нэг байна. Мөн тус сонин хувьсгал ялсны дараа Монгол ардын Намын бодлого, зорилтыг дагнан сурталчилсан хэвлэл байснаараа онцлогтой юм. “Монголын үнэн” сонин “Газар бүрийн ардууд нэгдэгтүн!” уриатай, “Түмэнд тунхаглан зарлах бичиг” хэмээх Монголын шинэ ардын засаг байгуулах журам”, “Монгол Улсын энэ цагийн байдал ба ардын намын бүтээх зүйлүүд”, “Түр засгийн газрыг баталсан бичиг”, “Олон монгол цэргийн ах дүү нарт сонсгох нь” зэрэг албан ёсны баримт бичгийг нийтэлж байснаар тус сонины ач холбогдлыг тодорхойлж, уг сонин тухайн цаг үедээ ус агаар мэт хэрэгтэй чухал үүрэг хүлээж, биелүүлж байжээ.

Судлаач “Монголын үнэн” сонин түүхэнд анх удаа хувьсгалч, ангич,

намч хэвлэлийн шинж төрхийг илэрхийлэн гарч ирсэн төдийгүй 1921 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалыг ялалтад хүргэхэд хамтын ухуулагч, хамтын суртал нэвтрүүлэгч, хамтын зохион байгуулагчийн үүргийг гүйцэтгэжээ хэмээн тодорхойлсон байна. Судлаачийн “Монголын үнэн” сонины 6 дугаарын нийтлэлд дүн шинжилгээ хийсний үр дүнд тухайн сонины нийтлэлүүд агуулга, сэдвийн төлөвлөлтийг маш нямбай хийж, тэргүүн, дагавар өгүүлэл, албан бичиг баримтын агуулгад нийцүүлж захируулсан гадаад мэдээ, мэдээлэл ихэнх дугаарт нь гарч байсныг тодруулсан байна. Тухайн үед бичлэгийн төрөл, зүйлийг ашиглах хэрэгцээ шаардлага цаг үеийн байдалтай холбоотой байсан гэсэн дүгнэлт хийсэн байна. Тухайн хэвлэлийн дугаар бүрийн толгойд ямар нэг зүйлээс сэрэмжлүүлсэн, эсвэл уриалан дуудсан үгсийг бичдэг байсан байсныг судлаач гярхай ажиглаж, сонины гуравдахь дугаарын магнайд “Хятадын эзэрхэг харгисууд ба тэдэн лүгээ өнгө, мөнгөний тул нөхөрлөн бялдуучлагчдад битгий итгэгтүн. Тэднээр Улс төрөө засуулан боловсорсугай хэмээвээс мал сүргээ чоноор мануулан өсгөсүгэй хэмээсэнтэй адил бишүү” хэмээн бичсэнийг жишээ болгон авсан нь сонирхол татаж байна.

Энэ бүхнээс үзэхэд ард түмэн өөрсдөө сайн мэдэх мал аж ахуйн холбогдолтой зүйр үг, хэлц үгээр ард олноо ухааруулан сэнхрүүлэх арга замаар улс орноо мандуулан бэхжүүлэх үйл ажлыг тус сониноор дамжуулан гүйцэтгэж байжээ. Тэр үеийн сэхээтэн, нийтлэлчдийн уран чадвар, ухаан бодлоор урласан хурц дайчин нийтлэлүүдийн хүчээр Монгол орноо монгол хүн өөрөө удирдах сайхан

цагийг авчирсан байна гэж дүгнэж байна.

“1 990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв” хэмээх гуравдугаар дэвтрийн эхний бүлэгт зохиогч ЗСБНХУ-д өөрчлөн байгуу-лалт, ил тод байдал хэмээн улс төрийн шинэ нэр томъёог хэрэглэн гарч ирсэн М.С.Горбачевын эхлүүлсэн улс төрийн шинэчлэл Монгол оронд, тэр дундаа тэргүүн ээлжинд хэвлэл мэдээлэлд нөлөөлснийг онцлон тэмдэглэсэн байна. Монголд өөрчлөлт шинэчлэлтийн салхийг Лодонгийн Түдэв эрхлэгчтэй “Үнэн” сонин эхлүүлснийг дурдаад ерөнхий эрхлэгчийн авьяас билиг, мэдлэг чадвар, холч хараа энэ сониныг ардчилал шинэчлэлийн эхлэл тавьж хүндтэй гавьяаг байгуулахад чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байгаагаар олон жишээ баримтаар нотлон харуулсан байна. Бичлэгийн хуучирсан хэвшмэл арга хэлбэр, өнгөц хоосон магтаал, хэлбэр төдий ашиггүй шүүмжлэлээс зайлсхийж, оронд нь шинэ сэдэв эрэлхийлэх, цоо шинэ асуудлыг зоригтой хөндөх, шинжлэлт бичлэгт шилжих зорилт дэвшүүлж, сэтгүүлчдийг шахааж шаардаж эхэлсний үр дүнд 1986 онд “Өндөг”, “Ботго, унага, тугал”, “Тэжээлийн үйлдвэр тэжээлгэсээр байх уу?”, “Алдагдлын үүдийг хааж арвижихын уутыг нээе” зэрэг өгүүллийн жишээгээр харуулсан нь сонирхол татахуйц болжээ.

Энэ бүлгийн нэг гол онцлог нь 1980-аад оны сүүлч 1990 оны эхэнд Монгол Улс, Монголын ард түмний түүхийн шинэ үед “Үнэн” сонин нийтлэлийн зөв чиг хандлагаараа нийгмийн сэтгэл зүйг бэлтгэж, 90-ээд оны ардчилсан хувьсгалыг бэлтгэхэд ерөнхий эрхлэгч Л.Түдэвийн зөв арга

барил, бүтээлч үйл ажиллагааны үр дүнд “Үнэн” сониныг ардчилал шинэчлэлийг Монголд эхлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хэвлэл мөн гэж дүгнэсэн явдал юм.

“Чөлөөт ардчилсан хэвлэлүүд Монголд үүсч хөгжсөн нь” хэмээх дараагийн бүлэгт 1990-ээд оны чөлөөт ардчилсан хэвлэлийн эхлэлийг тавьсан “Цагийн толь”, “Шинэ толь”, “Ардчилал” сонин, тэднийг үүсгэн байгуулсан Дарь.Сүхбаатар, Л.Амарсанаа болон уг сониныг үүсэх шалтгааныг бий болгож, үүсгэн байгуулагч нь “Монголын ардчилсан холбоо эвсэл” буюу Монголд ардчиллыг үүсгэн байгуулсан С. Зориг, Ц. Элбэгдорж, Э. Бат-Үүл зэрэг залуус гэдгийг дурдаад, эдгээр чөлөөт хэвлэлийн үйл ажиллагаанд үнэнчээр зүтгэсэн анхдагч сэтгүүлчдээр Дарь.Сүхбаатар, С.Баяр, Ш.Мягмарсамбуу, Д.Нинж, Л.Амарсанаа, Б.Эрдэнэбаатар, Нанж.Лхагва, Ц.Дагданготов, С.Цогтсайхан, Г.Бадамсамбуу, С.Адъяахүү, Ч.Куланда⁴ нарыг нэрлэсэн байна. Мөн тухайн үед гарч байсан чөлөөт хэвлэлийн зарим нийтлэлд ажиглалт хийж, санаа бодлоо хэлсэн төдийгүй, тухайн үеийн чөлөөт хэвлэлийг гаргаж байсан хүмүүстэй ярилцлага хийж, үйл явдалд биеэр оролцсон хүмүүсээс баримт нотолгоотой дурсамж яриаг авч өөрийн бүтээлдээ баримт болгож ашигласан нь бодит үнэнийг тогтоох чухал ач холбогдолтой юм.

“Чөлөөт ардчилсан хэвлэлийн үзэл санаа Монголд дэлгэрч төрөөс хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэхийг зорьсон нь” хэмээх гуравдугаар бүлэгт 90-ээд оны ардчилсан хувьсгал Монгол оронд зах зээлийн чөлөөт эдийн засаг үүсч хөгжих цоо шинэ нийгмийн харилцааг авчирснаараа онцлогтой төдийгүй энэ үйл явц Монгол оронд шинэ Үндсэн

хууль бүрэлдэх үндэс суурийг тавьж, бусад хууль тогтоомжийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн гаргах, шинэ нийгмийн хөгжлийн чиг хандлага, үйл ажиллагаатай уялдуулан өөрчлөх шаардлага урган гарсан тухай, Төрөөс чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэх хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх бодлого барьж, 1992 оны шинэ Үндсэн хуульд хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой чухал заалтууд орсныг тодорхой жишээ баримттай дурдаж, 1998 оны 8-р сарын 28-нд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсан талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

Энэ ботийн “Монгол дахь чөлөөт хэвлэлийн цаашдын төлөв” хэмээх дөрөвдүгээр бүлгийн онцлог бол “Монгол оронд чөлөөт сэтгүүл зүйн суурь тавигдаж, бие даасан чөлөөт хэвлэл гарах бодит хөрс бий болсон” гэсэн проф. М.Зулькафилийн тэмдэглэн хэлсэн хоёр чухал дүгнэлтийг иш үндэс болгон манайд 1913-1920 оны үе д гарч байсан “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд чөлөөт хэвлэлийн зарим шинж, элемент байсныг тодотгон талбарлажээ. Мөн чөлөөт хэвлэлийг Монголд төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулсан, оруулж буй ОНМХ-үүдийг тодорхой жишээ баримт-тад үндэслэн нэрлэж, Монголд чөлөөт сэтгүүл зүй төгс утгаараа бүрэлдэн төлөвшихөд наад зах нь 50 жил шаардлагатай хэмээн дүгнэсэн явдал юм. Судлаач АНУ болон бусад орон чөлөөт хэвлэлтэй болоход 100-150 жил шаардагдсаныг харгалзан үзээд имй дүгнэлт хийсэн байна.

Монголын шилдэг сэтгүүл зүй судлаач, нийтлэлч, эрдэмтэн багш нартай чөлөөт сэтгүүл зүйн төлөвшил,

цаашдын хөгжлийн талаар санаа бодлыг нь тусгасан ярилцлагуудаар өөрийн бүтээлээ улам баримтжуулсан байгаа нь энэ бүлгийг уншсан хэн бүхэнд өгөөжтэй, танин мэдэхүйн чухал ач холбогдолтой болжээ.

Номын “Ардчилсан чөлөөт хэвлэлийн амьд гэрчүүд юуг өгүүлэв” хэмээх дараагийн бүлэгт зохиогч ардчилсан хувьсгалын дараах 20 гаруй жилд манай оронд чөлөөт хэвлэл үүсч, бүрэлдэн төлөвшихөд гар бие оролцсон улс төрч, сэтгүүлчидтэй ярилцаж, сонин хэвлэлд нийтлүүлж байсныгаа нэгтгэн энэ бүлэгт багтаажээ. Нэг нийгэм нөгөө нийгмээр солигдож, Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжиж, чөлөөт хэвлэл үүсэх торгон агшинд хэн ямар үүрэгтэй оролцсон болоод хэн энэ үйл явдлыг хэрхэн тосч авч байсан тухай амьд гэрчүүдийн түүхэн үнэнийг нотлон ярьсан нь тухайн үеийн тухай сонирхолтой түүхийг олж харахад туслахуйц болжээ. Мөн энэ бүлгийнхээ төгсгөлд “Гэрэл зураг түүх өгүүлнэ” хавсралтаар тухайн үед гарч байсан чөлөөт хэвлэлүүдийг баримтжуулан зургаар үзүүлсэн нь чухал нэмэлт мэдээлэл өгч байна.

“**М**онголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь” хэмээх дөрөвдүгээр дэвтэрт мэргэжил нэгт нөхдийнхөө бүтээлд задлан шинжилгээ хийж, алдаа оноог шүүн тунгаасан шүүмжүүдээ оруулснаас гадна Монголд чөлөөт хэвлэл үүсэн бүрэлдэж, төлөвшихөд үнэтэй хувь нэмэр оруулсан нэртэй сэтгүүлч, нийтлэлчдийн бүтээл, туурвилаас оруулжээ. Мөн номынхоо эхэнд сэтгүүл хэмээх эрхэм алдрыг нэр төртэй авч явахын тулд сэтгүүлч хүн заавал эзэмших дадал, суурь мэдлэгийн

чухлыг, уран чадвар сэтгүүл зүйн хөдөлгөгч хүч мөн гэдгийг цохон тэмдэглэхийн ялдамд энэ ур чадварыг хаанаас, юунаас олж авч суралцах вэ гэдэгт тодорхой хариулт өгснөөрөө онцлогтой. Тухайлбал, уран чадварыг төгс эзэмшихийн тулд бичиж, нийтлэх гэж байгаа зүйлийн зохиомж, үгийн сонголт, бичлэгийн төрөл зүйлийн сонголт, дүр дүрслэл хамгаас чухал юм гэдгийг тайлбарласан байна. Мөн сэтгүүлч хүн сэтгүүл зүйн бичлэгийн үндсэн гурван элементийг маш сайн эзэмшиж, гойд анхаарах ёстойг сануулаад, гарчгийг яаж өгснөөс үзэгч, уншигчдын сэтгэлийг татах эсэх их хамаардаг, сэтгүүлч нийтлэлийн гарчгаараа уншигч, үзэгчийн нүдийг соронзон адил татдаг болох ёстой юм, бүр ная, ерээд оны үеийн зарим содон гарчигтай нийтлэл өнөөдөр ч үнэ цэнэтэй хэвээр байгааг жишээ татан тайлбарласан байна.

Анхаарал татсан өөр нэг онцлог зүйл бол зохиогч Монголд чөлөөт хэвлэл бүрэлдэн төлөвшихөд ерээд онд манайд бий болсон ардчилал шинэчлэлийн нөлөө их боловч, Монгол дахь ардчилсан чөлөөт хэвлэлийн эх ундарга Туул гол Тэрэлжийн өврөөс эх авдагийн нэгэн адил Монголын хэвлэл 1913 оны “Шинэ толь хэмээх бичиг” сониноос үүсэн салбарлаж өнөөг хүрсэн түүхтэй гэдгийг баримтаар баталгаажуулаад, манай сэтгүүл зүйн нэрт судлаачид доктор, профессор М.Зулькафиль, Л.Норовсүрэн нарын “Шинэ толь хэмээх бичиг” сонины нийтлэлийн агуулга, бүтэц, нийтлэлд хийсэн ажиглалт шинжлэл болон эрдэм шинжилгээний хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэл зэргээр жишээлэн баримтжуулжээ.

Сэтгүүлчдийн бүтээлээ туурвидаг арга барил, сэдвээ олдог онцлогийг

өөрсдийн нь хэлснээр буулгасан төдийгүй сэтгүүл зүй судлаач, сэтгүүл зүйн ангийн оюутануудад хичээл заадаг багш нарт санаа аваасай гэсэн зөвлөгөө хүртэл өгсөн нь ач холбогдолтой болжээ. Мөн Монголын сэтгүүл зүйн салбарт оюун ухаан, ухамсарт амьдралынхаа багагүй хугацааг чин сэтгэлээсээ зориулсан үзэг нэгтэй, сэтгэл нэгтэй зүтгэж яваа эрдэмтэн судлаач, сэтгүүлчдийнхээ тухай хийж байгаа ажил, хийсэн бүтээсэн бүтээлийг нь үнэлэн цэгнэж, тодорхойлон өгүүлсэн нь уг зохиолыг бүтээсэн эрхэм судлаачийн өөрийнх нь дотоод мөн чанар, сэтгэлийн илэрхийлэл гэлтэй. МУСГЗ, ахмад сэтгүүлч Х.Цэвлээгийн номын тухай “Сэтгүүлчийн ширээний ном бичсэн хүний тухай өглэх нь” бүтээлд Х.Цэвлээ Монголын сэтгүүл зүйд ямар хүндтэй байр эзлэх ёстой хүн бэ гэдгийг энэ хүний тухай

өөрийн сэтгэлдээ байдаг дүр, уран бүтээлтэй нь холбон илэрхийлж гаргасан танин мэдэхүйн хувьд үр өгөөжтэй болжээ. Мөн “Орчин үеийн сэтгүүл зүй” номын тухай шүүмжид доктор, профессор М.Зулькафилийг “Монголын сэтгүүл зүйн цорын ганц онолч” хэмээн онцгойлон тодотгож хэлсэн нь тухайн эрдэмтнээс Монголын сэтгүүл зүйд оруулсан хувь нэмрийг онож өгсөн үг хэмээн ойлгож байна.

“XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал” хэмээх

тавдугаар ботийг бүхэлд нь XXI зууны Монголын сэтгүүл зүйн хөгжил, чөлөөт хэвлэлд тулгамдаж буй асуудалд зориулагджээ. Монголын сэтгүүл зүйн хөгжилд санаа тавьж, түүнд гар бие, сэтгэлээ зориулж явдаг хэн бүхэн засч залж санаа тавих олон асуудал энд байна гэдгийг зохиолч цохон тэмдэглээд “Архаг өвчнөөсөө ангижран салцгаая” гарчгийн дор дээрх санаагаа өнөөдрийн сэтгүүл зүйн хөгжилд саад болж байгаа дутагдал, доголдлыг зарим хэвлэл мэдээллийн хэрэгслийн

жишээн дээр тайлбарласнаараа онцлогтой юм. “Өнөөдөр” сонины нэг дугаарт сэтгүүлч Ш.Даваадорж

“Монголын хатиг бэтэгтэй сэтгүүл зүй” нийтлэл бичиж, Монголын сэтгүүлчдийн гал тогоо бузартаж байгаа тухай эмзэг сэдвийг хөндсөнийг, мөн сэтгүүлч И.Рэнчинханд “Сэтгүүлчид маань...” нийтлэлд сэтгүүлчид зөвхөн

мөнгөнд дуртай болж байгаа төдийгүй эх хэлний мэдлэг чадвар нь нимгэрэн ядуурч байгааг сэрэмжлүүлэн анхааруулсныг энэ бүтээлдээ онцлон тэмдэглэжээ.

Энэ бүлгийн өөр нэгэн онцлог нь өнөөгийн сэтгүүл зүйн гал тогоонд багтаж, “Сэтгүүл зүй” хэмээх нэг завинд хамт сууж яваа үг нь мэргэн, үзэг нь хурц сэтгүүлчид санаа авч бүтээл туурвилдаа ашиглаж, жинтэй бүтээл гаргаасай гэсэн чин сэтгэл тээж олон олон сэтгүүлч, нийтлэлчийн бүтээлд бичсэн шүүмжээ оруулсан нь үнэтэй

«

Энэ бүлгийн өөр нэгэн онцлог нь өнөөгийн сэтгүүл зүйн гал тогоонд багтаж, “Сэтгүүл зүй” хэмээх нэг завинд хамт сууж яваа үг нь мэргэн, үзэг нь хурц сэтгүүлчид санаа авч бүтээл туурвилдаа ашиглаж, жинтэй бүтээл гаргаасай гэсэн чин сэтгэл тээж олон олон сэтгүүлч, нийтлэлчийн бүтээлд бичсэн шүүмжээ оруулсан нь үнэтэй бөгөөд чухал ач холбогдолтой болжээ

»

бөгөөдчухал ач холбогдолтой болжээ. Мөн тэдний дотор “Эх ба Эцэг” эссэг зохиогчийн уран чадварын тухай”, “Тамга ба Бөх судлаач сэтгүүлчдийн зарим нийтлэлийг сонжин шинжихүй”, “Монгол адууны тамганы ойллого” зэрэг шүүмж нь алдаа оноог нь шударгаар шүүн тунгааж, цаашдын уран бүтээлд нь хэрэг болж, санаа авууштай үнэлэлт дүгнэлт хийснээрээ онцлогтой юм.

“Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэлийн хүрээний бичиг” сонины уламжлал ба шинэчлэлийн уялдаа холбоог тодруулж, “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МОНТА” сонинуудын нийтлэлд задлан шинжлэл хийж, монгол бичиг, орос хэлнээс орчин цагийн кирилл бичигт хөрвүүлсэн нь оюутан болон судлаач нарт гарын авлага, судлагдахуун болгох боломжийг бүрдүүлж өгчээ. “Нийслэл хүрээний сонин бичиг” сонин нь “Шинэ толь хэмээх бичиг” сонины үзэл санаа, үйл хэргийг залгамжлагч гэдгийг олон талаас нь цөөнгүй сурвалжаар баталгаажуулж, улс орноо бүхий л талаар цэцэглэн хөгжиж, мандан бадруулахад, тус сонинд ажиллаж байсан дэвшилт үзэлт сэхээтэн, нийтлэлчид хоёргүй сэтгэлээр хандаж, бүтээлээ чөлөөтэй туурвиж байсныг олон жишээ баримтаар нотлон харуулснаараа энэ бүтээл онцлогтой болсон байна. Доктор Т.Баасансүрэн Монголын сэтгүүл зүйн шүүмж, шүүмжлэлийг хөгжүүлэхэд үнэтэй бөгөөд тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн судлаач мөн.

Сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн дээрх бүтээлүүдэд сэтгүүл зүйн хөгжлийн 100 жилийн түүхэн хөгжлийн асуудлыг тоймлон, орон зай он цаг хугацааны өргөн хүрээнд нэгтгэн дүгнэж, задлан шинжилснээрээ нөр их хөдөлмөр, хүч, цаг хугацаа, сэтгэл

шингэсэн Монголын сэтгүүл зүйн түүхэнд үнэтэйд тооцогдох бүтээл болжээ.

Ишлэл

- 1 Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. х.4-5.УБ.
- 2 Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. х.14.УБ.
- 3 Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. УБ. х.108.
- 4 Баасансүрэн Т. 2010. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” цуврал боть.Дэд дэвтэр. х.160-161. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009-2010. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. I-VI дэвтэр. УБ.
2. Баасансүрэн Т нар. 2002. МОНТА буюу МОНЦЭМЭ: түүний өчигдөр ба өнөөдөр, маргааш. УБ.
3. Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн уран чадварын асуудал: уламжлал ба шинэчлэл.УБ.
4. Баасансүрэн Т. 1989. Эрэл, бодол, эргэцүүлэл. УБ.
5. Баасансүрэн Т. 2013.Сэтгүүл зүйн судлаач, нийтлэлч Ломбын Норовсүрэн. УБ.
6. Баасансүрэн Т. 2013. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн онолч, доктор профессор М. Зулькафиль.
7. Баасансүрэн Т нар. 2013. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн нэрт судлаач Гэндэнжамцын Дэлэг.
8. Зулькафиль М. 2013. Сэтгүүл зүйн тайлбар толь.УБ.
9. Зулькафиль М. 2008. Орчин үеийн сэтгүүл зүй.УБ.
10. Норовсүрэн Л. 2004-2007. Монголын нийтлэл. Боть I-III. УБ.

11. Норовсүрэн Л. 2001-2004. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Боть I-III. УБ.

Резюме

В данной статье автор всесторонне анализирует основные научные работы по СМИ, включенные в пятитомную монографию под общим названием “Возникновение и формирование независимой демократической печати в

Монголии” видного учёного по журналистике, доктора исторических наук, профессора Т.Баасансуре́на. Автор выделив особенностями каждой книги делает вывод о том, что научные работы профессора Т.Баасансуре́на являются не только большим вкладом для дальнейшего развития монгольского журналистиковедения, но и ценными учебными пособиями для будущих журналистов, работников СМИ и исследователей журналистики.